



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААННУУР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 5/01

Гурвансайхан

2025 оны цалингийн сан батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.5, 59.1.7, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.7, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.1, 57.2.2, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382, 2024 оны 238 дугаар тогтоол, Монгол Улсын Их хурлын 2007 оны 73, 2019 оны 21 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засаг даргын орлогч, 1 дүгээр багийн Засаг дарга, 2 дугаар багийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга, Санхүү албаны дарга нарын 2025 оны цалингийн санг хавсралтаар баталсугай.

2. Уг албан хаагчдын цалин хөлсийг холбогдох хууль тогтоомж, шийдвэрийн дагуу тооцон олгохыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Л.Шижирболд)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн мэргэжилтэнд даалгасугай.

ДАРГА



Д.ОТГОНСҮРЭН

672601001